



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/797

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, бусад зайлшгүй арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах дараах зардлуудыг санхүүжүүлсүгэй. Үүнд:

-Шүүхийн шинжилгээний албаны барилгын дулааны болон цэвэр, бохир усны шугам хоолойн засварын зардалд 6,064,750 (зургаан сая жаран дөрвөн мянга долоон зуун тавь) төгрөг

-Хаус хороололд баригдаж буй ламтаны өргөөний зардалд 9,900,000 (есөн сая есөн зуун мянга) төгрөг,

-Арвайхээр сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт аймгийн мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл залуучуудын хөгжлийн газрын харъяа хамгаалах байр, цагдаагийн газрын конторын барилгуудад шилэн кабелийн бараа материалын зардал болон шилэн кабелийн газар шорооны ажлын зардалд 13,796,000 (арван гурван сая долоон зуун ерэн зургаан мянга) төгрөг

-Зэвсэгт хүчний 113 дугаар ангийн аж ахуйн барилгын ажлын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг

-Монголын ардчилсан холбоо байгуулагдсаны 30 жилийн ойн баярын арга хэмжээний зардалд 15,000,000 (арван таван сая) төгрөг

-Сант сумын Засаг даргын Тамгын газрын шатахууны зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг

-Статистикийн хэлтэст урсгал засварын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг нийт 53,760,750 (тавин гурван сая долоон зуун жаран мянга долоон зуун тавь) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101521